

ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН СЭРГЭЭН ЗАСАХЫН ТАСГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Б.Эрдэнэчимэг, Н.Занди, Т.Дулмаа, Л.Түвшинтөгс, Р.Оюунханд
Геронтологийн үндэсний төв
e-mail: gerontocenter@mongol.net

Abstract

CURRENT SITUATION OF REHABILITATION CARE SERVICE OF REHABILITATION CABINET OF NATIONAL GERONTOLOGY CENTER

B.Erdenchimeg, N.Zandi, T.Dulmaa, L.Tuvshintogs, R.Oyunkhand
National gerontology center
e-mail: gerontocenter@mongol.net

Introduction

Since the establishment of National gerontology center in 2005, the rehabilitation cabinet is run by one physician and a nurse.

Goal: Determine the types and needs of rehabilitation care service for the older persons who are serviced by national gerontology center's rehabilitation cabinet.

Materials and methods: The general 5 indicators of physical development is defined by 7 categories for 100 elderly aged between 55 and 64, who were serviced by the National gerontology center in April to June of 2012. The types and needs of rehabilitation care service is determined by the questionnaire which consists of 20 items with open and closed end for 150 elderly aged 55 and above for female and 60 and above for male. The results were typed in SPSS 12.0.

Results: The mean age of survey involved elderly was 60.1 ± 3.2 . While 35.3 percent were male, 64.7 percent female.

In terms of mostly used types of rehabilitation care were paraffin (29%), electrophoresis (14%) and electromagnetic therapy (12%). The needs of rehabilitation care were determined to have rehabilitation hospital (48%), increase number of elderly rehabilitation sanatorium (18%), increase the number of specialized physicians and nurses (14%), access to home care (10%) and improve the accessibility of rehabilitation room (10%).

Conclusions

1. The mostly provided type for the elderly serviced by National Gerontology center from rehabilitation care was thermotherapy and acupuncture from traditional medicine care.
2. The rehabilitation care needs are to have rehabilitation hospital, increase number of elderly sanatorium and increase number of specialized physicians and nurses in rehabilitation.

Key words: rehabilitation care, older persons, needs

Үндэслэл: Геронтологийн үндэсний төв 2005 онд байгуулагдсан цагаас хойш сэргээн засах эмчилгээний 1 эмч, 1 сувилагчтайгаар сэргээн засахын тусламж

үйлчилгээг настуудад үзүүлсээр ирсэн. Геронтологийн үндэсний төвөөр үйлчлүүлэгч настуудын тоо жилээс жилд нэмэгдэж байгаатай холбоотой настанд үзүүлж буй тусламж үйлчилгээндээ сэргээн засах эмчилгээний нэр төрлийг олшруулж, аппарат тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах талаар анхаарч ажиллаж байна.

Геронтологийн үндэсний төвийн сэргээн засах эмчилгээний тасгаар үйлчлүүлэгч настуудын сэргээн засах тусламж үйлчилгээний төрөл, хэрэгцээг тогтоохоор зорилоо.

Зорилго

Геронтологийн үндэсний төвийн сэргээн засах эмчилгээний тасгаар үйлчлүүлэгч настуудын сэргээн засах тусламж үйлчилгээний төрөл, хэрэгцээг тогтоох

Зорилт:

1. Геронтологийн үндэсний төвийн сэргээн засах эмчилгээний тасгаар үйлчлүүлэгч настуудын сэргээн засах тусламж үйлчилгээний төрлийг тогтоох
2. Геронтологийн үндэсний төвийн сэргээн засах эмчилгээний тасгаар үйлчлүүлэгч настуудын сэргээн засах тусламж үйлчилгээний хэрэгцээг тогтоох


Материал, арга зүй

Геронтологийн үндэсний төвийн сэргээн засах эмчилгээний тасгаар 2012 оны 4-6 дугаар сард Геронтологийн үндэсний төвөөр үйлчлүүлэгч настуудын сэргээн засах тусламж үйлчилгээний төрөл, хэрэгцээг тодорхойлохдоо 60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй нийт 150 наснаас 20 асуумж бүхий судалгааны картыг ашиглав. Судалгаанаас гарсан үр дүнг SPSS 12.0 програмд шивж, статистик боловсруулалтыг хийлээ.

Үр дүн

Судалгаанд хамрагдсан настуудыг насны бүлгээр ангилж үзэхэд 55-59 нас 29%, 60-64 нас 29%, 65-69 нас 22%, 70-74 нас 13%, 75-79 нас 3%, 80-84 нас 3%, 85 дээш нас 1%, дундаж нас 60.1 ± 3.2 байв. Хүйсний хувьд эрэгтэй 35.3% (53 настан), эмэгтэй 64.7% (97настан) байсан ба эмэгтэй настууд илүү үйлчлүүлсэн байна.

Сэргээн засах эмчилгээнд хамрагдсан байдлын хувьд физик эмчилгээний төрлөөр авч үзэхэд цахилгаан гүйдлийн эмчилгээнээс тогтмол гүйдлийн эмчилгээ (электрофорез) 14 хувь, нам, дунд давтамжит импульсийн гүйдлийн эмчилгээ (искра, ТЕНС) 4 хувь, цахилгаан соронзон долгион эмчилгээнээс цахилгаан ба соронзон эмчилгээ (УВЧ, МАГ) 12 хувь, гэрлийн эмчилгээнээс нил улаан, үзэгдэх гэрэл эмчилгээ 13 хувь, дулааны эмчилгээнээс парафин 29 хувь, механик хүчин зүйлийн эмчилгээнээс хэт авианы эмчилгээ (УЗТ) 5%, утлага эмчилгээ 3 хувь, уламжлалт эмчилгээнээс зүү 11 хувь, төөнө засал 2 хувь, иллэг бариа, бумба 5% хувь, хөдөлгөөн эмчилгээ 2 хувь хийгдсэн байна. Судалгаанд хамрагдсан настуудын 80 хувь сэргээн засах эмчилгээ, 20 хувь уламжлалт эмчилгээ хийлгэсэн байна. Сэргээн засах эмчилгээний төрлөөс дулааны эмчилгээ парафин, уламжлалт эмчилгээнээс зүү эмчилгээ зонхилох хувийг эзэлж байна. Сэргээн засах эмчилгээний үр дүнг авч үзэхэд 96 хувь нь сайжирсан, 4 хувь нь хэвэндээ байлаа.



Судалгаанд хамрагдсан настуудаас сэргээн засах тусламж үйлчилгээний төрлүүдээс түлхүү авах хүсэлтэй байгааг тодруулахад дийлэнх хувь буюу 25 хувь нь хөдөлгөөн засал эмчилгээг сонгосон байна.

Судалгаанд хамрагдсан настуудаас сэргээн засах тусламж үйлчилгээний хэрэгцээг тодруулахад 48 хувь нь сэргээн засах эмнэлэгтэй болох, 18 хувь нь настны сувиллын тоог нэмэгдүүлэх, 14 хувь нь настны мэргэшсэн эмч сувилагч нарын тоог нэмэгдүүлэх, 10 хувь нь гэрийн тусламж үйлчилгээ авах, 10 хувь нь сэргээн засах эмчилгээний өрөө тасалгааны хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгтэй гэж үзсэн байна. Сэргээн засах тасгаар үйлчлүүлэгчдийн 92 хувь нь сэтгэл ханамж маш сайн, 8 хувь нь сайн гэж үнэлсэн байна.

Дүгнэлт

1. Геронтологийн үндэсний төвөөр үйлчлүүлэгч настууд сэргээн засах эмчилгээний төрлөөс дулааны эмчилгээ, уламжлалт эмчилгээнээс зүү эмчилгээнд түлхүү хамрагдсан байна.
2. Настнуудын хувьд сэргээн засах эмнэлэгтэй болох, настны сувиллын тоог нэмэгдүүлэх, мэргэшсэн эмч сувилагч нарын тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байна.